



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 405

Улаанбаатар хот

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын "Зөвшөөрөл олгох тухай" 2019 оны 168, "Зам-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд баригдсан барилга байгууламжийн талаар авах арга хэмжээний тухай 2019 оны 206, "Замын-Үүдийн дулааны станц"-ын талаар авах арга хэмжээний тухай 2020 оны 123 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Барилга, хот байгуулалтын яамны харьяа Дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 72,976,017,905.09 (далан хоёр тэрбум есөн зуун далан зургаан сая арван долоон мянга есөн зуун таван төгрөг есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Замын-Үүдийн дулааны станц" ТӨҮГ-т балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, "Замын-Үүд дулааны станц" ТӨҮГ-ын захирал У.Санрайжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцож нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Энэ тогтоолд заасан үл хөдлөх хөрөнгөд хамаарах газар эзэмших эрхийг "Замын-Үүд дулааны станц" ТӨҮГ-т шилжүүлэн эзэмшүүлэх, асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх бүртгэлд тусгах арга хэмжээ авах;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэхүү тогтоол гарсантай холбоотойгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 320 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ) тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001309

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 09 дүгээр сарын .....-ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ХАРЬЯА ДЭД БҮТЦИЙН АШИГЛАЛТЫН  
ӨМНӨХ ЗАХИРГААНЫ ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ "ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ  
СТАНЦ" ТӨҮГ-Т БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Шилжүүлэх дүн (төгрөг)
<b>Төслийн 1-р багц. Дулаан хангамж</b>				
1	Бойлерийн өрөөний тоног төхөөрөмж	багц	1	6,189,959,510.41
2	Насосны өрөөний тоног төхөөрөмж	багц	1	37,343,060.22
3	Цэвэр усны насос өрөөний тоноглол	багц	1	24,191,657.76
4	Нүүрс дамжуулах системийн материал, тоног төхөөрөмж	багц	1	410,767,054.44
5	Хоолой ба дагалдах хэрэгсэл	багц	1	119,133,935.26
6	Агааржуулалт, агааржуулагч	багц	1	46,030,753.52
7	Цахилгаан тоног төхөөрөмжийн материал	багц	1	1,288,696,735.54
8	Нүүрс дамжуулагчийн тэжээл	багц	1	73,267,802.67
9	Барилга угсралт	багц	1	7,027,027,995.20
10	Гадна дулаан шугам сүлжээ	багц	1	4,572,750,477.97
11	Бусад	багц	1	16,752,164,182.12
12	Ус дулаан дамжуулах төв №1-№12	багц	1	3,610,299,507.77
<b>Төслийн 2-р багц. Ус хангамж, ариутгах татуургын барилга, байгууламж</b>				
13	Ус цэвэршүүлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж	багц	1	20,039,284,653.50
14	Бохир ус цэвэршүүлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж	багц	1	7,902,195,438.11
15	Гүнийн худаг болон цэвэр усны шугам сүлжээ	багц	1	3,588,937,321.59
16	Цэвэр усны өргөлтийн насос станц	багц	1	788,553,053.78
17	Чөлөөт бүс бохир усны өргөлтийн насос станц	багц	1	505,414,765.22
<b>Нийт дүн</b>				<b>72,976,017,905.09</b> (далан хоёр тэрбум есөн зуун далан зургаан сая арван долоон мянга есөн зуун таван төгрөг есөн мөнгө)